талыг хамарсан байх) шинэчлэн боловсруулж. албаны хэмжээнд ил тод болгох;

2 . "Цагдаагийн байгууллагын алба хаагчдыг сургах, удирдах албан тушаал дэвшүүлэх. сонгон шалгаруулах журам”-ыг яаралтай боловсруулан цагдаагийн байгууллагад удирдах албан тушаалд сонгон шалгаруулалтын үндсэн дээр дэвших "мерит" тогтолцоог бий болгох.

3 .Тухайн удирдах албан тушаалын ажлын байрны шалгуур, шаардлагыг хангаж байгаа алба хаагчдын талаархи дэлгэрэнгүй судалгаа, "Удирдах албан тушаалтны цахим мэдээллийн сан” бүрдүүлэн бүтээлчээр ашиглах.

***Э.Мэндсайхан -*** *Хуулъ сахиулахын удирдлагын академийн 8032 дугаар дамжааны суралцагч, цагдаагийн хошууч*

***Д.Энхбаяр -****ХСИС-ийн Удирдлагын академийн Цагдаагийн удирдлага, стратегийн профессорын багийн ахлах багш, цагдаагийн дэд хурандаа*

# ЦАГДААГИЙН ХЭСГИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН АЖИЛЛАХ НӨХЦЛИЙГ ХАНГАХ ТАЛААРХИ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИНД ХИЙСЭН ДҮН шинжилгээ

***Хураангуй:*** *Аливаа байгууллага нь ажилтныхаа гүйцэтгэх үүргийг нарийвчлан тодорхойлж, ажиллах таатай орчин нөхцлийг бүрдүүлж чадвал тавьсан зорилго. хүссэн амжилтандаа хүрэх боломж нөхцөл тэр хэмжээгээр нэмэгддэг гэж судлаачид үздэг.*

*Энэхүү өгүүлэлд цагдаагийн хэсгийн төлөөлөгчийн ажиллах орчин нөхцлийг бүрдүүлэх, хангахад чиглэгдсэн эрх зүйн зохицуулалт Монгол Улсын хууль тогтоомжид хэрхэн тусгагдсан талаар түүвэр хийж, түүндээ товч шинжилгээ хийн үнэлэлт, дүгнэлт өгөх талаар товч дурдсачсэн болно.*

***Түлхүүр*** *үгс: хэсгийн төлөөлөгч (Section Representative), ажлын байр (Workplace), эрүүл, аюулгүй орчин (Healthy and safe environment), Ххдөлмөрийп нөхцөл (Labor condition), ажиллах нөхцөл-(working conditions).*

Аливаа байгууллага тавьсан зорилгоо биелүүлэхийн тулд менежментийн сайн тооцоолсон бодлого боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх удирдлагын сайн менежерүүдийн багийг бүрдүүлж, ажиллах хүний нөөцийг сонгон авахад анхаарлаа хандуулах шаардлагатай байна.

Ажиллах хүний нөөцийг бүрдүүлсэний дараа тэдний ажиллах орчин нөхцлийг хэрхэн бүрдүүлсэнээс хамаарч тэдний ажлын үр дүн тодорхойлогдоно.

*"ажиллах орчин нөхцөл "* гэж юу болох түүнд эрх зүйн ямар шалгуур, шаардлага тавигддаг талаар товч авч үзье.

Эрдэмтэн судлаачдын ном бүтээлүүдээс ажиллал орчин нөхцлийн талаар судалж үзэхэд дараах үндсэн элементийг чухалчлан авч үздэг болох нь харагдаж байна. Үүнд:

1. Ажлын байрны тав тухтай орчин
2. Хөдөлмөрийн *(ажлын байрны)* эрүүл ахуй
3. Аюулгүй байдал
4. Ажил гүйцэтгэхэд шаардлагатай техник, бусад хэрэгслийн хангамж
5. Ажлын байрны эрсдэл.

Дээрхи хүчин зүйлс буюу үндсэн элементүүдийг бүрэн хэмжээнд хангагдсан нөхцөлд ямар ч ажлын бүтээмж өндөр байхаас гадна алба хаагч. ажилтан сэтгэл ханамжийн хувьд ч өндөр байдаг.

Ийм орчин нөхцлийг бүрдүүлэх нь ямар ч байгууллагын нэн тэргүүний зорилтуудын нэг байхаас гадна дээрхи элементүүд цогц байдлаар бүрдсэн үед сая ажиллах орчин нөхцөл зохих хэмжээнд хангагдсан гэж үзэж болно.

Эндээс үзэхэд ажлын байр аюулгүй байдлын хувьд ч эрүүл ахуй, хангамжийн талаасаа ч бүрэн төгс хэмжээнд хангагдсан байх нь онолын хувьд харьцангүй ойлголт бөгөөд гагцхүү ажиллах бүхий л боломж нөхцлөөр хангахад чиглэсэн үйл ажиллагааг цаг үргэлж явуулж байх нь байгууллагын удирдлагын салшгүй нэг хэсэг байх учиртай юм.

Цагдаагийн албан хаагч ая тухтай, эрүүл, аюулгүй орчинд ажлаа гүйцэтгэх, түүнчлэн нэн шаардлагатай техник хэрэгсэл, ажлын хувцас, бусад шаардлагатай зүйлээр бүрэн хангагдсан байх нь тэдэнд ажилдаа тэмүүлэх урам зоригыг өгч, ажлын бүтээмжийг нэмэгдүүлээд зогсохгүй төрийн болон бусад үйлчилгээнд иргэд, олон нийт сэтгэл ханамжтай байх нөхцөл бүрдэх тал бүрийн ач холбогдолтой.

Өнөөдөр төрийн албан хаагчийн ажиллах орчин нөхцөл, ажлын байрны тав тухтай орчин, түүнийг сайжруулах асуудал Монгол Улсын хууль тогтоомжид хэрхэн тусгалаа олсон талаар товчхоныг авч үзье.

*Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль.*

[1]Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль. //Төрийн мэдээлэл. 2008. №1

Энэ хууль нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи төрийн бодлого. үндсэн зарчмыг тодорхойлж. төрийн байгууллагын удирдлага. хяналтын тогтолцоо. ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал [2]. эрүүл ахуйн шаардлага[3], стандартыг хангах, ажилтан, хөдөлмөр эрхлэгч иргэнийг эрүүл. аюулгүй орчинд ажиллах нөхцлийг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилготой юм.

Түүнчлэн хуулийн 5.2. дахь хэсэгт зааснаар ажил олгогч нь ажилтныг ажлаар. хөдөлмөрийн аюулгүй байдал. эрүүл ахуйн шаардлагад тохирсон нөхцөлөөр хангах, хөдөлмөрийн үр дүнд нь тохирсон цалин хөлс олгох үүрэгтэй байна.

Цагдаагийн хэсгийн төлөөлөгчийн хувьд дээрхи хуульд тусгагдсан ажиллах орчин нөхцлийг хэн, хэрхэн хангах, өөрөөр хэлбэл, томилсон цагдаагийн байгууллага уу? эсвэл тухайн аймаг, орон нутгийн удирдлага, түүнчлэн сумын Засаг дарга уу? гэдэг нь тодорхой бус учраас хуулийг нэр мөр ойлгож хэрэгжүүлэхэд учир дутагдалтай байна.

Мэдээж хэрэг хэсгийн төлөөлөгчийн ажиллах нөхцлийг хангах, сайжруулах тухай асуудал түүнийг шууд томилсон цагдаагийн төв байгууллагатай холбоотой асуудал мөн боловч Монгол Улсын хэмжээнд байгаа бүх аймгийн сумын хэсгийн төлөөлөгчийн ажиллах орчин нөхцлийг улсын төсвөөр санхүүждэг цагдаагийн байгууллага дангаараа бүрэн хариуцах боломжгүй тул энэ асуудалд тухайн аймаг орны удирдлагын болон сумын дэмжлэг, туслалцааг авах, түүнийг зохион байгуулах ажлын уялдаа холбоог хангах нь чухал байна.

*Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль[4]:*

Уг хуулиар ажил олгогч нь ажилтныг ажлаар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон нөхцлөөр хангах, хөдөлмөрийн үр дүнд нь тохирсон цалин хөлс олгох, энэ хууль болон хөдөлмөрийн ба хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод журамд заасан үүргээ биелүүлэх үүрэгтэй болох талаар тусгасан байна.

Харин “ажилтан нь аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хөдөлмөрийн нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, өөрөө болон төлөөллийн байгууллагаараа дамжуулан эрх, хууль ёсны ашиг

[1] ажлын байр — ажилтны гүйцэтгэх ажил үүрэгтэйгээ холбоотойгоор хүрэлцэн очих ёстой ажил олгогчийн шууд ба шууд бус хяналтын дор байх бүх байр;

[2] хөдөлмөрийн аюулгүй байдал - хөдөлмөрлөх явцад хүний эрүүл мэнд, хөдөлмөрлөх чадварт үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллийн түвшин нь эрүүл ахуйн зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрээгүй байх;

[3] ажиллах нөхцөл - хөдөлмөрлөх явцад хүний ажиллах чадвар, эрүүл мэндэд дагнасан буюу хамссан байдлаар нөлөөлөх ажлын байрны болон үйлдвэрлэлийн орчин.

[4]Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль. //Төрийн мэдээлэл. УБ. 1999. №21

сонирхлоо хамгаалах зорилгоор эвлэлдэн нэгдэх, хууль тогтоомжид заасны дагуу тэтгэвэр, тэтгэмж авах, хөдөлмөрийн ба хамтын гэрээ, хэлэлцээрт заасан бусад эрх, хонгололт эдлэх эрхтэй байхаас гадна үнэнчээр хөдөлмөрлөх, хуулиар тогтоосон нууцад хамаарах ажил. үүрэгтэй нь холбоотой нууцыг хадгалах, хөдөлмөрийн ба хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод журам, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нийтлэг шаардлагыг сахин биелүүлэх үүрэгтэй" хэмээн зохицуулжээ.

Цагдаагийн хэсгийн төлөөлөгчийн хувьд дээрхи хуулийн заалтанд тусгагдсан ажиллах нөхцлийг хэн, хэрхэн хангах, өөрөөр хэлбэл, хэсгийн төлөөлөгчөөр томилсон цагдаагийн байгууллага уу? эсвэл тухайн аймаг, орон нутгийн удирдлага, түүнчлэн сумын Засаг дарга уу? гэдэг нь тодорхой бус учраас хуулийг нэр мөр ойлгож хэрэгжүүлэхэд учир дутагдалтай байна.

Өнөөдөр хэсгийн төлөөлөгчийн ажиллах нөхцлийг хангах, сайжруулах тухай асуудал түүнийг шууд томилсон цагдаагийн төв байгууллагатай холбоотой асуудал мөн боловч Монгол Улсын хэмжээнд байгаа бүх хэсгийн төлөөлөгчийн ажиллах нөхцлийг улсын төсвөөр санхүүждэг цагдаагийн байгууллага дангаараа бүрэн хариуцах нь нэг талаасаа боломжгүй юм.

Тэгэхээр энэ асуудалд тухайн нутгийн захиргааны байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоо, санаачлагаас ихээхэн хамаарах асуудал юм.

*Төрийн албаны тухай хууль :*

Энэ хуулийн 14.1.3. дахь хэсэгт цалин хөлсөө нэмэгдүүлэх, албан тушаалын зэрэглэл дэвших, ажиллах нөхцөл, баталгаагаа сайжруулахтай холбогдсон саналыг дээд шатныхаа албан тушаалтанд амаар буюу бичгээр тавих, 27.1.2. дахь хэсэгт албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцлөөр хангуулах, 33.6. дахь хэсэгт төрийн байгууллага дараах чиглэлээр тусгайлсан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлж ажиллахаар зохицуулалт орсон байна. тухайлбал:

- төрийн албан хаагчийн сургалт;
- төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа

Төрийн албан тухай хуулийн 35 дугаар зүйлд Төрийн албаны Зөвлөлийн 13 бүрэн эрхийг хуульчлан баталгаажуулсан байх бөгөөд 35.1.13 дахь хэсэгт төрийн байгууллагаас төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг арга зүйн удирдлагаар хангаж байх, 39.1.3. дахь хэсэгт төрийн жинхэнэ албан хаагчаас цалин хөлс, ажиллах нөхцөл, баталгааны талаар гаргасан бусад маргааныг шийдвэрлэх талаар тусгасан байна.

[1]Төрийн албаны тухай хууль. //Төрийн мэдээлэл. УБ. 2002. №28

Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн ажиллах орчин нөхцлийг сайжруулахтай холбоотой дээрхи заалтууд төрийн тусгай алба хаагч болох цагдаагийн алба хаагч. түүний дотор хэсгийн төлөөлөгчийн ажиллах орчин нөхцлийг сайжруулахад нэгэн адил хамааралтай болно.

*Цагдаагийн албаны тухай хууль*[1]*:*

Цагдаагийн алба хаагч. түүний дотор хэсгийн төлөөлөгчийн ажиллах нөхцлийг сайжруулах, тэдний албан үүргээ гүйцэтгэхтэй холбоотой эрх зүйн баталгаа дараах байдлаар тусгалаа олжээ.

16 дугаар зүйл:

- Засгийн газар санхүү, материал, техникийн хангамжийн хувьд цагдаагийн байгууллагын хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийг Засгийн газар батална.
- Цагдаагийн байгууллага Засгийн газар, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, гүйцэтгэх ажлаас бусад асуудлаар хууль тогтоомжийн хүрээнд өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлж үр дүнг тайлагнана.
- Аймаг, нийслэлийн Засаг дарга хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд хариуцсан нутаг дэвсгэртээ нийтээр дагаж мөрдөх журам тогтоож, түүний хэрэгжилтийг хангуулахыг тухайн нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад хуулиар хүлээсэн үүргийнх нь хүрээнд даалгана.
- Засгийн газар болон нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргаас цагдаагийн байгууллагатай харилцах талаар энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
- Засаг дарга тухайн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын даргыг албаны орон сууцаар хангах арга хэмжээ авна.

Хуулийн дээрхи зохицуулалтаас дүгнэхэд Засаг дарга аймаг, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын даргыг албаны орон сууцаар хангах арга хэмжээ авахыг тусгасан нь дэвшилттэй боловч харин тухайн аймгийн суманд хэсгийн төлөөлөгчөөр анх томилогдон очиж байгаа цагдаагийн алба хаагчийн талаар тусгайлан заасан бол тэдний ажиллах. амьдрах баталгаа хуулиар баталгаажих боломжоор хангагдах байжээ гэж үзэж болох байна.

65 дугаар зүйлийн 65.5. дахь хэсэг. Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд иргэдийн Төлөөлөгчдийн Хурал. Засаг дарга бүх талын туслалцаа үзүүлэх үүрэгтэй гэж заасан нь агуулгын хувьд

[1] Цагдаагийн албаны тухай хууль. //Төрийн мэдээлэл. УБ.2017. №8

цагдаагийн алба хаагч, түүний дотор хэсгийн төлөөлөгчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх эрх зүйн зохицуулалт тусгагдсан байна гэж дүгнэж болно.

87 дугаар зүйлд алба хаагчийн эдийн засгийн баталгааны талаар авч үзсэн бөгөөд энэ нь дараах байдлаар тусгагдсан байна. Үүнд:

- Засгийн газар цагдаагийн алба хаагчийн хэвийн ажиллах нохцлийг бүрдүүлнэ.
- Цагдаагийн алба хаагч ээлжийн амралтаараа өөрийн, эсхүл эхнэр, нөхрийн төрсөн нутагт ирэх, очих замын зардлыг тухайн үед мөрдөж байгаа автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож 2 жилд нэг удаа олгоно.
- Цагдаагийн алба хаагч шилжин ажиллах болсноос шалтгаалан эхнэр, нөхөр нь хөдөлмөрийн гэрээгээ цуцлахад хүрвэл түүнийг тэргүүн ээлжид ажлаар хангах бөгөөд ажлаар хангаагүй нөхцөлд ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа цалингийн доод хэмжээгээр тооцож улсаас олгоно.
- Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, онц байдлын үед болон голомтын бүсэд үүрэг гүйцэтгэсэн цагдаагийн алба хаагчид албан томилолтын зардлыг ердийн үеийнхээс гурав дахин нэмэгдүүлж олгоно.
- Цагдаагийн байгууллага алба хаагчийг өндөржүүлсэн бэлэн байдал зарласан үед болон ажлын бус цагаар, шөнийн ээлжид, хээрийн сургууль, дадлагын үеэр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь хүнсний болон эдийн хангалтаар хангаж, хоолны зардлыг олгоно. Цагдаагийн алба хаагчид олгох хүнсний болон эдийн хангалт, хоолны зардлын хэмжээг цагдаагийн төв байгууллагын дарга тогтооно.
- Нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор цагдаагийн байгууллагад ажиллахаар томилогдсон алба хаагчид уналга, ачаа тээш, зам хоногийн зардал, түүний гэр бүлийн болон асрамжид нь байдаг хүмүүст уналга, ачаа тээшийн зардлыг тухайн үед мөрдөж байгаа онгоц, автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож олгоно.
- Цагдаагийн байгууллагын захиалгаар гадаад улсын цагдаагийн их, дээд сургуульд суралцагч цагдаагийн алба хаагчийн суралцах хугацааны цалин хөлс, ирэх, буцах тээврийн зардлыг төр хариуцна.
- Цагдаагийн алба хаагчийн цалин хөлс нь үндсэн цалин, цолны цалин болон доор дурдсан нэмэгдлээс бүрдэнэ:
- төрийн тусгай алба хаасан хугацааны;
- албан ажлын онцгой нөхцөлийн;
- цагдаагийн мэргэжлийн зэргийн;
- эрдмийн зэрэг, цолны;

- хуульд заасан бусад.[1]

*89 дүгээр зүйлийн 89.1. дэх хэсэг.* Аймгийн төвөөс бусад суманд томилогдсон цагдаагийн алба хаагчийн ажиллах нөхцлийг бүрдүүлэх, албаны орон сууц. уналга, холбооны хэрэгслээр хангах үүргийг цагдаагийн байгууллага хүлээнэ.

*89 дүгээр зүйлийн 89.2. дэх хэсэг.* Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшлыг 5 жил тутам олгох бөгөөд мөнгөн урамшил олгох журмыг Засгийн газар батална гэж заасныг шууд утгаараа цагдаагийн хэсгийн төлөөлөгчийн ажиллах баталгаатай холбоотой заалт гэж ойлгож болно.

*90 дүгээр зүйлийн 90.1. дэх хэсэг.* Цагдаагийн алба хаагчид жил бүр ажлын 15 өдрийн үндсэн амралт олгож, биеэр эдлүүлнэ.

*90 дүгээр зүйлийн 90.2. дахь хэсэг.* Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий цагдаагийн алба хаагчид алба хаасан 2 жил тутам ажлын 3 өдрийн, цагдаагийн бусад алба хаагчид алба хаасан 5 жил тутам ажлын 3 өдрийн нэмэгдэл амралт олгоно.

*90 дүгээр зүйлийн 90.3. дахь хэсэг.* Ажлын зайлшгүй шаардлагаар нэмэгдэл амралтаа биеэр бүрэн эдэлж чадаагүй цагдаагийн алба хаагчид түүний зөвшөөрснөөр хоногт ногдох цалинг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн урамшил олгоно гэж хуульчилсан бөгөөд хуулийн энэхүү зохицуулалтаар аймгийн хөдөө, суманд байгаа хэсгийн төлөөлөгч хүссэн цагтаа ээлжийн амралтаа авч бүрэн эдлэх, эсвэл албан ажлын зайлшгүй шаардлагаар нэмэгдэл амралтаа биеэр бүрэн эдэлж чадаагүй үед түүний зөвшөөрснөөр хоногт ногдох цалинг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн урамшил хэлбэрээр олгож байсан тохиолдол байхгүй байгаа нь төсвийн хүндрэлтэй энэ цаг үед хэрэгжих боломжоор бага байна.

Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/223 тоот тушаалд зааснаар ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ хийхэд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Стандартчилал, тохиролын үнэлгээний тухай хууль, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөл, түүний ангилал, хүчин зүйл, хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ MNS 5080:2001’" стандарт”, "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл

[1]Мөн хууль. //Төрийн мэдээлэл. 2017. №8

мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин., Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2015" стандартыг мөрдлөг болгон ажиллах орчныг халуун дулаан, гэрэлтүүлэг. хэт өндөр дуу чимээ, агаарын орчны хорт бодисын зөвшөөрөгдөх хэмжээ, сэтгэл зүй, физилиогийн хүчин зүйлээр нь хөдөлмөрийн тохиромжтой, зөвшөөрөгдсөн. хортой аюултай түвшинд ангилсан байдаг.

Гэтэл цагдаагийн хзсгийн төлөөлөгчийн ажлын нөхцлийг дээрх түвшний аль нэгэнд шууд хамааруулан үзэх боломжгүй байгаа нь тэдний хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангахад төвөгтэй нөхцөл байдлыг үүсгэж байна.

**Дүгнэлт.**

Өнөөдөр цагдаагийн байгууллагад ажлын байрны тав тухтай орчны стандарт хэв загвар гэж байхгүй нь цагдаагийн алба хаагчийн ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажил үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай ажлын байрны нөхцлийг бүрдүүлэхэд хүндрэл учрах нэг хүчин зүйл болж байна.

Цагдаагийн алба хаагч өөрийн хийж гүйцэтгэх ажил үүрэгт тохирсон, стандарт шаардлага хангасан ажлын байранд ажилласнаар сэтгэл зүйн болоод бусад хангамжийн таатай мэдрэмжийг авч, улмаар ажилдаа сэтгэл хангалуун, урам зоригтой байхад чиглэсэн үйл ажиллагаа байх учиртай. Гэтэл цагдаагийн хэсгийн төлөөлөгчийн ажлын байрны тав тухыг суманд албан үүргээ гүйцэтгэх ажлын байр /кобан/ байгаа эсэхээр дүгнэж байгаа нь учир дутагдалтай гэж үзэж байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 16.1 дэх хэсэгт "Засгийн газар санхүү, материал, техникийн хангамжийн хувьд цагдаагийн байгууллагын хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлнэ", 87.1. дэх хэсэгт "Засгийн газар цагдаагийн алба хаагчийн хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлнэ”, 16.2. дахь хэсэгт "цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийг Засгийн газар батална" гэж заасан ч бодит байдал дээр цагдаагийн хэсгийн төлөөлөгчийн ажил, үүргээ хэвийн, хараат бус байдлаар гүйцэтгэхэд шаардлагатай техник болон хэрэгслийн хангамж хүрэлцээгүй байна.

Түүнчлэн ажиллах нөхцлөө сайжруулахын тулд зарим сумын хэсгийн төлөөлөгч өөрийн зардлаар албан өрөөгөө засч, нэлээд олон сумын хэсгийн төлөөлөгч албаны унаа байхгүй тул дуудлага, мэдээллийг шалгах болон албаны ажилдаа хувийн машинаа ашиглаж байна.

Эдгээр байдлыг хэсгийн төлөөлөгчийн албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөл, баталгаагаар хангах талаар удирдлага, зохион байгуулалтын тодорхой шинэчлэл хийгдээгүй, нэгэн хэвийн байдлаар хандаж ирсэнтэй холбоотой гэж үзэж байна.

Дээрхи бүгдийг нэгтгэн авч үзвэл цагдаагийн хэсгийн төлөөлөгчийн ажиллах нөхцлийг бий болгох чиглэлээр гаргасан эрх зохицуулалт тодорхой хэмжээгээр байгаа боловч хэрэгжилт нь хангалтгүй. шаардлагатай хөрөнгө нь төсөвт суугаагүй. нөгөө талаараа цагдаагийн хэсгийн төлөөлөгчийн ажлын байрны стандарт шаардлага байхгүй байгаа нь өнөөгийн байдлаар шаардлагатай ажлын байрны орчин нөхцлийг бүрдүүлэхэд учирч байгаа хүндрэл бэрхшээл юм байна гэж үзлээ.

**Санал.**

1. ЦЕГ-ын удирдлагаас санаачлан цагдаагийн хэсгийн төлөөлөгч нарын ажлын байрны орчин нөхцлийг судлах ажлын хэсэг байгуулан, шаардагдах хөрөнгө, мөнгөний тооцоо гаргах;
2. Цагдаагийн хэсгийн төлөөлөгчийн ажлын байрны орчин нөхцөл, шаардлагатай бусад байдлыг тусгасан стандарт шаардлагыг боловсруулж, Цагдаагийн албаны тухай хуулинд тусгах;
3. Цагдаагийн хэсгийн төлөөлөгч нарын ажлын байрны орчин нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр гаргсан хууль тогтоомжуудын хэрэгжилтийг судлах ажлын хэсэг байгуулан судлуулж, хэрэгжилтэнд тулгарч хүндрэл бэрхшээл, түүний шалтгаан нөхцлийг илрүүлэх ажлыг зохион байгуулах.

***Б.Энх-Амгалан*** *- ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн 8032 дугаар дамжааны суралцагч, цагдаагийн хошууч*

***Д.Энхбаяр*** *- ХСИС-ийн Удирдлагын академийн Цагдаагийн удирдлага, стратегийн профессорын багийн ахлах багш, цагдаагийн дэд хурандаа*

## ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭР ХҮНД, ТҮҮНД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛ, ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН ҮНЭЛЭМЖ

***Хураангуй:*** *Энэхуу илтгэлээр цагдаагийн байгууллагын нэр хунд, түүнд нөлөөлөх хучин зүйл, иргэд, олон нийтийн зугээс өгч буй үнэлэмж зэрэгт дун шинжилгээ хийж унэлэлт, дугнэлт өгөхийг зорилоо.*

***Түлхүүр*** *уг: Цагдаагийн баигууллага, Нэр хүнд, Алба хаагч*

*Аливаа төрийн болон хууль сахиулах тусгайлсан чиг уургийг хэрэгжуулэгч байгууллагын өмнөө тавьсан зорилго, зорилтоо ханган биелүүлэх, амжилттай ажиллах нь олон чухал хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд тууний нэг нь удирдлагын зөв, оновчтой арга барилыг бух шатанд нэвтруулэх, улмаар иргэд, олон нийтийн итгэл, дэмжлэг, туслалцааг байнга авахад оршиж байдаг.*